

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/004/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2026 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16. № 01/1281
танай _____-ны № _____-т

“ХӨВСГӨЛ ДУЛААНЫ СТАНЦ”
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
П.САНЛИГРЭНЧИН ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хөвсгөл Дулааны Станц” ТӨХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд дансны авлага өмнөх оноос 2,318.2 сая төгрөгөөр өссөн нь төсөвт байгууллагуудын тогтмол зардлын төсвийг Сангийн яамнаас хасах тодотгол хийсэнтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 125.6 сая төгрөгийн 4 зөрчил илэрч, 1.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2.5 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 121.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын шийдвэрээр “Хөвсгөл Дулааны станц” ТӨХК-ийн хувьцааны 66 хувийг Эрчим хүчний яаманд, үлдсэн 34 хувийг Эрчист Монгол ХХК-ийн эзэмшилд шилжүүлсэн байна.

Тайлант онд 19.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 21МВт-ын станцын өргөтгөлийн барилга угсралтын ажил дуусаж, 2025 оны 12 сарын 19-ны өдөр улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	558,411,523.28	206,156,878.21
1.1.2	Дансны авлага	303,003,003.73	2,621,233,074.38
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	20,933,865.68	169,179,133.26
1.1.6	Бараа материал	664,231,330.95	2,207,001,520.73
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,546,579,723.64	5,203,570,606.58
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	29,765,207,303.21	28,709,129,100.67
1.2.2	Биет бус хөрөнгө	494,661,487.14	8,585,806,873.95
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	82,182,610.71	76,715,394.64
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	30,342,051,401.06	37,371,651,369.26
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	31,888,631,124.70	42,575,221,975.84
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	0.00	2,526,587,194.83
2.1.1.3	Татварын өр	0.00	141,318,856.08
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	8,825,079.24	56,513,687.69
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,825,079.24	2,724,419,738.60
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	82,182,610.71	76,715,394.64
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	82,182,610.71	76,715,394.64
2.2	Өр төлбөрийн нийт дүн	91,007,689.95	2,801,135,133.24
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	33,981,526,313.42	33,981,526,313.42
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,334,309,479.71	3,334,309,479.71
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	462,079,200.00	8,554,756,543.38
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-5,980,291,558.39	-6,096,505,493.93
2.3.11	Эздийн өмчийн дүн	31,797,623,434.74	39,774,086,842.58
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	31,888,631,124.69	42,575,221,975.82

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	8,658,470,063.88	11,090,271,887.20
2	Борлуулалтын өртөг	10,012,045,568.51	10,345,835,458.78
3	Нийт ашиг (алдагдал)	-1,353,575,504.63	744,436,428.42
5	Хүүгийн орлого	2,131,989.93	10,183,276.80
8	Бусад орлого	1,932,617,805.08	1,105,293,870.19
9	Борлуулалт, маркетингийн зардал	547,879,441.13	650,461,419.91
10	Ерөнхий ба удирдлагын зардал	346,765,922.17	468,084,119.71
12	Бусад зардал	356,224,539.26	412,828,360.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	-1,534,107.40
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-669,695,612.18	327,005,568.39
19	Орлогын татварын зардал	0.00	32,700,556.83
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-669,695,612.18	294,305,011.56
24	Орлогын нийт дүн	-669,695,612.18	294,305,011.56

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.4	3,334,309,479.7	462,450,000.0	(5,286,010,541.5)	32,492,275,251.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(3,716,301.0)	(3,716,301.0)
3	Залруулсан үлдэгдэл	33,981,526,313.4	3,334,309,479.7	462,450,000.0	(5,289,726,842.5)	32,488,558,950.6
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(669,695,612.2)	(669,695,612.2)
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.4	3,334,309,479.7	462,079,200.0	(5,980,291,558.4)	31,797,623,434.7
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(410,518,947.1)	(410,518,947.1)
11	Залруулсан үлдэгдэл	33,981,526,313.4	3,334,309,479.7	462,079,200.0	(6,390,810,505.5)	31,387,104,487.6
13	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	8,092,677,343.4	-	8,092,677,343.4
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	294,305,011.6	294,305,011.6
17	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	33,981,526,313.4	3,334,309,479.7	8,554,756,543.4	(6,096,505,493.9)	39,774,086,842.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	11,063,532,036.78	11,063,532,036.78
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	9,996,875,957.44	9,996,875,957.44
1.1.4	Буцаан авсан албан татвар	5,048,684.00	5,048,684.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	1,061,607,395.34	1,061,607,395.34
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,519,527,221.65	10,519,527,221.65
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,217,864,312.00	3,217,864,312.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,095,800,233.49	1,095,800,233.49
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	2,380,019,121.55	2,380,019,121.55
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	683,112,275.12	683,112,275.12
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,897,413,242.50	1,897,413,242.50
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,017,527,071.30	1,017,527,071.30
1.2.9	Бусад мөнгөн зарлага	227,790,965.69	227,790,965.69
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	544,004,815.13	544,004,815.13
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	29,483,276.80	29,483,276.80
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	19,300,000.00	19,300,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	10,183,276.80	10,183,276.80
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	925,742,737.00	925,742,737.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	923,245,737.00	923,245,737.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,497,000.00	2,497,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-896,259,460.20	-896,259,460.20
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-352,254,645.07	-352,254,645.07
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	558,411,523.28	558,411,523.28
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	206,156,878.21	206,156,878.21

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2024 оны гүйцэтгэл	2025 он			Харьцуулалт		
					Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Аудитлагдсан Гүйцэтгэл	2024 гүйцэтгэлээс	Батлагдсан төл-өөс	
					х	1	2	3	4	5
1	Боловсруулсан	ДЭХ	мян.Гкал	84.2	85.5	85.2	85.2	1.0	(0.3)	
	Дотоод хэрэгцээний дулаан эрчим хүчний зарцуулалт	хувиар	хувь	1.9	1.9	1.9	1.9	-	-	
		биетээр	мян.Гкал	1.6	1.6	1.6	1.6	-	-	
	Эрчим хүч түгээлт	ДЭХ	мян.Гкал	82.6	83.9	83.6	83.6	1.0	(0.3)	
2	Нийт орлого		сая.төг	10,593.2	12,325.0	12,205.7	12,205.7	1,612.5	(119.3)	
	Үүнээс:	Үйл ажиллагааны орлого	сая.төг	8,658.5	11,162.1	11,076.3	11,076.3	2,417.8	(85.8)	
		Үйл ажиллагааны бус орлого	сая.төг	107.1	162.9	129.5	129.5	22.4	(33.4)	
		Санхүүжилт (Улсын төсвийн татаас)	сая.төг	1,827.7	1,000.0	1,000.0	1,000.0	(827.7)	-	
3	Нийт зардал		сая.төг	11,262.9	12,029.1	11,878.7	11,878.7	615.8	(150.4)	
	Үүнээс:	Үйл ажиллагааны зардал	сая.төг	9,548.7	10,675.4	10,493.5	10,493.5	944.8	(181.9)	
					1,603.9	1,343.5	1,371.7	1,371.7	(232.2)	28.2
		Үйл ажиллагааны бус зардал	сая.төг	110.3	10.2	13.5	13.5	(96.8)	3.3	
4	Татварын өмнөх ашиг/алдагдал		сая.төг	(669.7)	295.9	327.0	327.0	996.7	31.1	
5	Татварын дараах ашиг/алдагдал		сая.төг	(669.7)	266.3	294.3	294.3	964.0	28.0	
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.1	1.0	1.0	1.0	(0.1)	(0.0)	
7	Нийт авлага		сая.төг	323.9	126.7	2,790.4	2,790.4	2,466.5	2,663.7	
	Үүнээс:	ЭХ-ний	сая.төг	302.0	126.7	2,437.7	2,437.7	2,135.8	2,311.0	
		Бусад	сая.төг	22.0	-	352.7	352.7	330.7	352.7	
8	Нийт өглөг		сая.төг	91.0	157.4	2,801.1	2,801.1	2,710.1	2,643.7	
	Үүнээс:	Урт хугацаат өр төлбөр	сая.төг	82.2	157.4	76.7	76.7	(5.5)	(80.7)	
		Богино хугацаат өр төлбөр	сая.төг	8.8	-	2,724.4	2,724.4	2,715.6	2,724.4	
9	Нийт ажиллагсдын тоо		тоо	133.0	130.0	130.0	130.0	(3.0)	-	
10	Нийт цалингийн сан		сая.төг	3,423.6	4,041.9	4,028.5	4,028.5	604.9	(13.4)	
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт		кг/Гкал	230.7	207.3	207.2	207.2	(23.5)	(0.1)	
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая.төг	722.0	1,610.9	8,824.9	8,824.9	8,103.0	7,214.1	
	Өөрийн хөрөнгөөр		сая.төг	722.0	1,610.9	732.2	732.2	10.3	(878.6)	
	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр		сая.төг	-	-	8,092.7	8,092.7	8,092.7	8,092.7	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,031.5 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,031.5 сая төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- ❖ Эрчим хүчний яамнаас тайлант оны алдагдал/зардлыг бууруулах зорилгоор үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг бага дүнгээр хянасан бөгөөд 701.4 сая төгрөгийн элэгдэл дутуу тооцоолсон, 330.1 сая төгрөгийн элэгдлийг илүү тооцоолж бүртгэсэн байна.

Энэ нь НББОУС 16-Үндсэн хөрөнгө: Элэгдэл хэсэгт "Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид системчилсэн сууриар хуваарилна", НБББББ-ийн, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэгт "тасралтгүй байх", 5.1.4 дэх хэсэгт "үнэн зөв байх" гэж заасныг тус тус зөрчсөн, Иж бүрэн байх, Үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байх тул залруусан.

Аудитаар нийт 125.6 сая төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 1.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 121.5 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг Хөвсгөл Дулааны станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчил нь тогтоосон материаллаг байдлаас 131.1 сая төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Томилолтоор явсан хугацаанд 1.6 сая төгрөгийн хоолны мөнгийг давхар тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх хэсэгт "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;" Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 Албан шаардлага

Анхны гэрээний үнийн 80.4 хувьтай тэнцэх 2.5 сая төгрөгийн худалдан авалтыг хийхдээ хуульд заасан гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэлгүй, Түвшин-Ундраа ХХК-иас шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ" гэж заасныг зөрчсөн, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Он дамнан хэрэгжиж буй гэрээт ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланд салгаж тайлагнаагүйгээс 121.5 сая төгрөг хэтэрсэн харагдаж байна. Энэ нь Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.3 дахь хэсэгт “Тухайн жилийн төсөвт он дамжин хэрэгжихээр тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, тайлбарт он дамжин хэрэгжиж байгаа талаар дурдана” гэж заасныг зөрчсөн байна.

Зөвлөмж: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг бэлтгэхдээ он дамнан хэрэгжиж буй гэрээт ажил болон, нэмэлт гэрээгээр хэрэгжиж буй худалдан авалтуудыг бүрэн тусгах.

Илрүүлэлт: Тайлант онд дансны авлага, өглөг өмнөх оноос 8.5 дахин өссөн байна. Энэ нь Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.10 дахь хэсэг Гүйцэтгэх захирал дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдлэнэ: 10.11.5-дахь хэсэгт “гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж: Төсөвт байгууллагын хувьд төсвийн жилийн төгсгөлд тарифын өөрчлөлт оруулсан нь төлөвлөх боломжгүй байсан бөгөөд тарифын өөрчлөлтийг орон нутгийн төсөв даахгүйд хүрч байгаа тул санхүүжилтийн өөр эх үүсвэрийг шийдүүлэх боломжтой эсэх талаар судалж, уламжлах арга хэмжээг авч ажиллах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн аудитаар										
Элэгдлийн зардлыг зөрүүтэй тооцоолсон	1	1,031.5			1	1,031.5	1	1,031.5		
Дүн	1	1,031.5			1	1,031.5	1	1,031.5		
Завсрын аудитаар										
ББӨ, ЕУЗ, БМЗ зөрүүтэй бүртгэсэн	1	34,160.0			1	34,160.0	1	34,160.0		
Өглөг бүртгээгүй бхад өмнөх оны түрээс шилжүүлсэн	1	56,063.6			1	56,063.6	1	56,063.6		
Дүн	2	90,223.6			2	90,223.6	2	90,223.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Жилийн эцсийн аудитаар									
Авлага, өглөг өмнөх оноос 8.5 дахин өссөн	1	-						1	-

Томилолтын зардал, хоолны зардал давхар олгосон	1	1,635.0	1	1,635.0				
Дүн	2	1,635.0	1	1,635.0			1	-
Завсрын аудитаар								
Түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлээгүй	1	1,654.6					1	1,654.6
Томилолтын анхан шатны баримт дутуу	1	2,180.0					1	2,180.0
НББББ шинэчлээгүй	1	-					1	-
Завсрын аудитаар баталгаажуулсан тайлан ирүүлээгүй, баримт материал хугацаа хоцроож ирүүлсэн	1	-					1	-
Дүн	4	3,834.6					4	3,834.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн аудитаар								
Он дамжин хэрэгжиж буй ажлыг төлөвлөгөө, тайланд тусгаагүй	1	121,515.8					1	121,515.8
Гэрээгүй ажил гүйлгээ санхүүжүүлсэн.	1	2,492.5			1	2,492.5		
Дүн	2	124,008.3			1	2,492.5	1	121,515.8
Завсрын аудитаар								
ХАА-ны баримтыг архивын нэгж болгоогүй	1	-					1	-
Шаардлага хангаагүй оролцогч шалгаруулсан	2	404,500.0			2	404,500.0		
Дүн	3	404,500.0			2	404,500.0	1	-